

СОЦИАЛИЗМААС ӨВЛӨЖ АВСАН “ХЭВШЛҮҮД”-ЭЭСЭЭ САЛЦГААЯ

С.Батхуяг, доктор (Sc.D.), профессор, МУБИС

Abstract: At the end of XX century, Mongolia has chosen humanitarian and democratic trends of social development and recognized the necessity for democratization of education, more specifically higher education. Even this process has been continuing more than 20 years, there is still no progress. Main reason of it is the use of different pedagogical and psychological approaches in education. In this paper, we have raised some ideas for changing our traditional-socialist approaches in education. It may start from the point of the innovation in whole system of education.

Түлхүүр үг: Нийгмийн хөгжлийн чиг баримжаа, социализм, хүмүүнлэг ардчилсан нийгэм, өөриймсөг хандлага, өөрийгөө үнэлэхүй, салбарын шинэчлэл

Удиртгал

Манай орны өнгөрсөн 70-80 жилийн түүх социализмтай салшгүй холбоотой байсан бөгөөд түүний ул мөр бидний өнөөдрийн амьдралд ч байсаар. Гэхдээ тэдгээрийн нэлээд нь өнөөдрийн нийгмийн амьдралд сөрөг нөлөө үзүүлсээр байгааг бид тэр бүр мэдрэхгүй байна.

Үүнийг тэрлэгч мань мэтийн үеийнхний 60-70 жил амьдарч байсан социалист нийгэм маань манай орны хүн амын 3-4 үеийнхний итгэл үнэмшил бүрэлдэн төлөвших хөрс суурь болж, ажил, амьдралынх нь утга учрыг тодорхойлж ирсэн бөгөөд тэр үеийн хэн бугай ч зайлж үл чадах бодит нөхцөл байдал байсныг үгүйсгэх аргагүйгээр үл барам түүний ул мөр өнөөдөр ч арилаагүй байна.

Тэр нь өнөөдрийн бидний өдөр тутмын үйл ажиллагаанд илрэн гарсаар, бид тэр бүрийг байх ёстой зүйлс мэтээр ойлгон, харин ч бүр хүмүүнлэг ардчилсан нийгэмд байх ёстой зарим хэм хэмжээг үүндээ зохицуулан “монголчлох” гэж оролдсоор, энэ мэт нь манай нийгмийн шинэчлэл, өөрчлөлтөд саад тээг болсоор байгааг энгийн юм шиг хэрнээ ихийг бодогдуулахуйц зарим жишээгээр харуулахын хамтад засаж залахын зарим санааг ч хөндөхийг хичээлээ.

1. Өөриймсөг бус хандлага

Социализмын үед бид “Чи нийгмийн төлөө ажиллах ёстой. Хувийн эрх ашгаа нийгмийн эрх

ашгаас дээгүүр тавьж болохгүй” гэж шаарддаг байсныг өнөөдрийн 40-өөс дээш насныхан бараг цөм мэднэ гэдэгт би итгэлтэй байна. Ийм шаардлагын улмаас өнөөдрийн дээрх насныхан өөрийнхөө болоод үр хүүхдийнхээ амьдралын төлөө хүлээх үүрэг, хариуцлагын талаар бага бодож, зөвхөн л өөрт оногдсон үүрэгт ажлаа “нэр төртэй” гүйцэтгэснээр үүргээ биелүүлж, амьдарч байна гэж үзэж хэвшчихсэнээс “Би юуны тулд яаж амьдрах ёстой юм бэ, миний хүн болж төрсний утга учир, үнэ цэнэ юугаар үнэлэгдэх юм бэ, амьдралын маань утга учир юу юм бэ” гэсэн асуултуудыг өөртөө тавьж бараг хэвшээгүйгээс гадна улмаар аливаа ажлыг ихэвчлэн хэн нэгний өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхийн төлөөнөө хийж түүнийг хийснээрээ наад зах нь хэн нэгэнд зэмлүүлэхгүй байгаадаа сэтгэл нь ханадаг болчихсон гэхэд хилсдэхгүй. Ингэснээр өөрийн үнэ цэнэ, нэр төрийг зөвхөн өрөөлд зэмлүүлэхгүй, үгэнд нь орж, санаанд нь нийцэх төдийхнөөр ойлгодог болсон нь ажиглагдсаар байгаагаас өөрөө өөрийнхөө чадал, чансааг бүрэн ашиглахыг хичээхийн оронд бие амар байж, зүгээр сууж цалин хөлс авахыг эрмэлзэх, ямарваа ажлыг хэн нэгний санаанд нийцүүлэхийн тулд хийж хэвшчихээд түүнээсээ салж чадахгүй байгаа нь өнөөдрийн төрийн ажилтнаас эхлээд сургууль, соёлд суралцаж байгаа оюутан, сурагчдын өдөр тутмын ажил, хичээл, сурлагадаа хандаж байгаа байдлаас байнга харагдсаар байна.

Гэтэл хүмүүнлэг, ардчилсан нийгмийн үед иргэн бүр өөрийнхөө болон өрх гэр, хань ижил, үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхны тулд бага наснаасаа эхлэн суралцан бие, санаа сэтгэлээ бэлтгэн ажиллаж амьдрах эрхтэй төдийгүй үүрэгтэй байдаг. Ингэж хүн “өөрийнхөө ирээдүйн төлөө” гэсэн өөриймсөг сэтгэл, итгэлтэй болох нь чухамдаа биеэ аваад явах чадвар, арга ухаантай болж төлөвшснөөр хувь хүн төдийгүй улс орон, ард иргэд нийтээрээ аз жаргалтай, сэтгэл хангалуун, аж төрж амьдрах нөхцөл боломж бүрдэх учиртай. Ингэхийн тулд эцэг, эх, сургууль, багш нарын өөрсдийн үр хүүхэд, оюутан, сурагчидтай ажилладаг арга барил, тавьдаг шаардлагын социалист маягийн өнгө аясыг өөрчлөхөөс боловсролын шинэчлэлийг эхлүүштэй санагдана.

Юун өмнө хүүхдүүдийнхээ бага ангид сурч байхаасаа эхлээд зөвхөн багш болон ээж ааваасаа

“сайн” үнэлгээ, дүн авахын төлөө хичээлдээ оролцож, даалгавраа хийдэг хандлагыг өөрчлөх шаардлагатай байна. Ээж, аав нь ч “За, өнөөдөр ямар дүн авав?” гэсэн утгатай асуулт асуудаг хандлагаа өөрчилж, “Өнөөдөр юу шинээр мэдэв?, юу сурав?” гэж асуудаг болох юм бол хүүхдүүд маань ядаж дүнгийн төлөө биш, “Нээрээ би чинь өнөөдөр юу ойлгож мэдэж, юу сурав?”, “Би саяны хичээлээс юуг шинээр сурч авав?” гэж эргэцүүлэн боддог болж, сурах үйлдээ өөриймсөг ханддаг болох нь гарцаагүй. Улмаар ямарваа нэг ажил, үйлийг хийхдээ “Би ер нь юуны тулд үүнийг хийх гэж байгаа билээ?” гэж эргэцүүлэн бодож, алив ажилд тодорхой зорилго, зорилттой, ухаалгаар ханддаг болох суурь тавигдана. Багш нар ч даалгавраа өгөхдөө “Үүнийг хийснээр та нар ийм юмыг ингэж хийж сурах зорилготой юм шүү” гэж даалгаврынх нь зорилго, зорилтыг тайлбарлаж өгдөг байвал суралцагчид нь хийх гэж байгаа даалгаврынхаа ач холбогдлыг ойлгож өөртөө ашигтай зүйл хийж байгаагаа ухаарч, ухамсартай, өөриймсөг хандах нь зайлшгүй.

Ингэж хичээл ном болон багшийн өгсөн гэрийн даалгавартаа өөриймсөг хандаж сурсан хүүхэд цаашид сурах үйлсдээ төдийгүй, өөртэйгөө холбогдох бүх зүйл, улмаар нийгмийн чанартай аливаа асуудал, ажил, үйлсэд бас өөриймсөг ханддаг болох нь гарцаагүй.

2. Өөрийгөө үл үнэлэхүй

“Өөрийгөө үнэлэх” нь чухамдаа зүгээр л нэг өөртөө дүн тавьж өөрийгөө “хуурна” гэсэн утгатай үг биш юм. Манай аль ч шатны сургуулийн багш нарт “үнэлэх” гэдгийг “дүгнэх”, “дүн тавих” гэж ойлгодгоос суралцагчдын “өөрсдийгөө үнэлэх” гэдгийг “байж боломгүй зүйл” мэт ойлгох нь түгээмэл ажиглагддаг. Уг нь “өөрийгөө үнэлэх” гэдгийг “Хүн ямар нэг ажил хийж гүйцээд уул ажлыг хийхийн өмнө тавьсан зорилго, зорилтын хэр хангагдсаныг өөрөө эргэж харж эргэцүүлэхийн нэр” гэж ойлговол зохилтой. Ингэснээр үйлийн эзэн өөрөө өөрийнхөө алдаа, оноог олж харж, өөрөөсөө сургамж авч, юугаа сайжруулан засах шаардлагатайгаа өөрөө мэдэрдэг сайн талтай. Гэтэл социализмын үеэс одоо хүртэл сургуулийн сурагч, оюутнаас эхлээд төрийн албан хаагчид маань хүртэл багш, сайд, дарга нар болон хянан шалгагчид л биднийг шалгаж үнэлэх ёстой мэтээр ойлгож тэднээс үнэлгээ авах, гаднаас ирэх хяналт, шалгалтыг хүлээх, ирэхлээр нь дараа яаж ийгээд гайгүй үнэлгээ, дүн авахын төлөөт “хамтаараа” чармайж, хичээж өнгөрөөх зорилготой ханддаг байснаас янз бүрийн шатны үзлэг, хяналт-шалгалтын ажлуудын тийм ч хүсэж хүлээдэг зүйл

байгаагүй билээ. Энэ нь чухамдаа тэр бүхний үр өгөөж тааруухан байсантай л холбоотой. Ингэснээрээ хүмүүс хянаж, шалгах ажлыг илүүц зүйл мэт ойлгох болж, ямар нэгэн ажлыг “хийсэн болох”-ын тулд хийж, эргэж хянаж шалгахын ач холбогдлыг ойлгохгүй байхад хүргэсэн хэрэг. Гэтэл хийснээ эргэж хянах нь хүний өөрийнхөө алдаа, оноог олж харж, засан залах, улмаар хөгжин боловсрохын хамгийн чухал, хамгийн хямд, хамгийн сургамжтай арга зам байдгийг манай хөгшид “хүн гишгэсэн мөрөө эргэж харах ухаантай байх ёстой юм шүү” гэж сургадаг байснаас харж болно л доо. Адаглаад д энэ үгийг ээж, аав, багш сурган хүмүүжүүлэгчид үр хүүхэд, шавь нартаа хэлдэг байвал зүгээр сэн.

Хүмүүнлэг, ардчилсан нийгмийн үеийн удирдлагын тогтолцоо нь чухамхүү энэ өөрийн үнэлгээнд тулгуурласан байдгаараа онцлог талтай. Гэтэл өнөөдөр манай төр засгийн эрх баригчдаас эхлээд албан байгууллагын дарга, эрхлэгч нарын дотор үүний учрыг сайн ойлгоогүйгээс ч юмуу, ойлгосон хэдий ч ярихаас хэтрэхгүй, яаж хэрэгжүүлэх арга замаа олохгүй яваа нь цөөнгүй байгаа нь нууц биш. Төрийн болоод хууль, хяналтын албаныхан ч нөгөө л хуучин хандлагаараа дээрээс нь үүрэг даалгавар өгч, эргэж хянан шалгах, өө, алдаа дутагдлыг нь илрүүлж арга хэмжээ авах төдийгөөр сайн сайхан болчих мэтээр хандаж ажилласаар байгаа билээ. Тэгээд олигтой сайн үр дүн гарахгүй байгаагийн хамаг бурууг бусад руу буюу олон түмэн рүү “чихдэг” арга барилыг бид бараг өдөр бүр, хурал, цуглаан, илтгэл яриа, тайлан дээрээс сонсож, харж байна. Гэтэл энэ бүхний цаад учир шалтгаан нь бидний ажлын арга барил хүмүүнлэг, ардчилсан нийгмийнхээ хэм хэмжээнд нийцэхгүй, хоцрогдчихоод байгааг ойлгохгүй байгаад оршиж байгаа юм шүү дээ.

Олон түмэн ч үүнийг бас сайн ойлгохгүй байгаагаасаа “Ингэж л дээрээс, хөндлөнгөөс нь даалгавар өгч, дараа нь шалгаж, үнэлж удирдах ёстой” гэж итгэсэн хэвээр байгаагаасаа болоод “худал амлаж, хуурмаг үнэлж, дүгнэсэн” хүмүүст “итгэж” тэднийгээ сайд, дарга, төрийн түшээ болгон дэвшүүлж, сонгосоор байгаа нь өнөөдрийн улс төрийн амьдралын маань бодит дүр зураг болоод байна.

Үүнээс гарах гол арга зам нь эрх мэдлийн төвлөрлийг зоригтойхон задалж, иргэд болон албан тушаалтан, нэгж хамт олонд итгэл, хариуцлага хүлээлгэн өөрсдийн үүрэгт ажилдаа эзэн нь болж хувийн болоод байгууллагын үйл ажиллагааныхаа зорилго, зорилт болоод ямар ажлыг, юуны тулд, яаж хийхээ өөрсдөө шийдэж, эцсийн үр дүн, үр

өгөөжийг нь анхны төлөвлөсөнтэйгээ харьцуулан үнэлж, алдаж оносон зүйлээ өөрсдөө олж харж, засан сайжруулж ажиллах боломжийг олгох явдал юм. Ингэснээр алдаагаа нууж “үнэлгээ” авахыг хичээх, хөндлөнгийн хүний зөвлөснөөр алдаагаа зассан болж нүд хуурах зэрэг явуургүй, бас дахин алдаа, дутагдал гаргахын үндэс шалтгаан нь хэвээрээ үлддэг байдал арилж, байгууллага, хамт олон, хүн бүхэн өөрөө өөрийнхөө ажил, хөдөлмөрийн эзэн нь болж алдаа, дутагдлаа засан амжилт, ахицаа мэдэрч, урамтай ажиллах нөхцөл бүрдэх учиртай. Гагцхүү үүний гарцаагүйд итгэж, гарах үр дүнг нь ард олон бид болон “дээр” маань байгаа дарга, сайд, төрийн түшээд олж харж, ойлгох нь чухал болоод байна.

Хувь иргэн, албан тушаалтан, хамт олон бүр ингэж өөрсдийн үйл ажиллагааныхаа эзэн нь байж, өмнөө тодорхой зорилготой, өөрсдийгөө мэдэрч, үнэлж ажилладаг болохын эхлэл нь мөн л сургуульд суралцаж байх үеэс тавигдах учиртай. Социализмын үеэс хүүхдүүдийг сургуульд байхаас нь зөвхөн багш л үнэлж, тэдэнд “Хүн ер нь бусдаар л үнэлүүлж байх ёстой юм байна” гэсэн итгэл, үнэмшил төрүүлж, ямар ч ажил, даалгаврыг ганцхан тэр үүрэг, даалгаврыг өгсөн хүнээс нь л үнэлгээ авахын тулд хийж байгаа байдлаар хандаж, чухам өөрийнхөө хувьд юу сурч, мэдэж, яаж хөгжиж байгаагаа мэдрэх, цаашдаа яаж хийвэл илүү үр өгөөжтэй болохыг олж харах хэрэгцээ, сонирхол огт төрүүлдэггүй нь өнөөдөр ч бараг бүх шатны сургуульд суралцагсдын хичээл, номондоо хандаж байгаа байдлаас харагдсаар байгаа билээ.

Ингэснээр өөрийн үйл хөдлөлд хяналт тавих хэвшилгүй, өөрийгөө үнэлэх үнэлэмжгүй, биеэ мэддэггүй, өрөөлийн худал, хуурмаг үнэлгээнд хууртаж явдаг, өөрийн гэсэн тодорхой зорилго, бодлогогүй, хийж бүтээснээ үнэлж өөрийгөө мэдрэн урамших зүйлгүй, нийгмийн дунд “хөвж” амьдардаг иргэн, мэргэжилтэн-бие хүн төлөвшиж байгааг боловсролын салбарынхан хамгийн түрүү ойлгууштай. Адаглаад л багш нар нь сурагчдад өгч байгаа даалгаврынхаа зорилго, зориулалтыг тайлбарлан, хурааж авч үзэж шалгахаасаа өмнө өөрсдөө хийсэн ажлаа хянаж шалгаад, тавьсан шаардлагыг нь хангах хэмжээнд болжээ гэж үзсэн хойноо шалгуулж үнэлүүлэхээр хураалгадаг болохыг шаарддаг болоход л хүүхдүүдийн хийсэн зүйлээ эргэж харж, өөрсдийн хийснээ хянаж үнэлдэг хэвшилтэй болоход их л нэмэр болох учиртай. Үүний тулд багш нар нь суралцагчдад өгөх даалгаврыг төлөвлөхдөө түүнийг ямар зорилготой, юуг, яаж хийж сургах гэж байгаагаа тодорхой төлөвлөн, даалгавраа өгөхдөө түүнийгээ

тодорхой тайлбарлан, шалгаж, үнэлэхдээ тавих шаардлага, шалгуураа урьдчилан сайн хэлж ойлгуулдаг байх шаардлагатай болно. Энэ нь суралцагчдын даалгавраа багшдаа өгөхийнхөө өмнө эргэж хянаж шалгах ажлын чиг баримжаа болж өгөх юм. Энэ нь хэтдээ өөрийнхөө хийсэн ажлыг эргэж өөрөө эргэж хянадаг хувийн хариуцлагатай иргэн, найдвартай мэргэжилтэн болж төлөвшихийн суурь болох нь гарцаагүй.

3. Амьдралынхаа утга учрыг дутуу ойлгохуй

Социализмын үеийнхний нэгэн гол итгэл үнэмшил нь “Би өнөөдөр нийгмийн төлөө, нийтийн тусын тулд ажиллах ёстой. Төр засаг миний өөрийн болоод үр хүүхдийн минь бүх хувь заяаг хариуцна. Ирээдүйнхээ төлөө санаа зовохын хэрэггүй. Би эд хөрөнгийн төлөө хөөцөлдөж болохгүй” гэсэн үзэл бодол байлаа. Ингэснээрээ тэр үеийнхэн өөрсдийн амьдралын утга учрыг “нийгмийн төлөө л ажиллах явдал” гэж ойлгон, насны эцэст илүү, дутуу зүйлгүй, бэлэн зэлэн юман дээр жаргах юм шиг бодож, чухамдаа өөрийн гэсэн хэтийн бодлогогүйгээр өдөр хоногийг өнгөрөөж, зөвхөн сайд, дарга нарынхаа өмнө, өгсөн үүрэг даалгаврыг нь биелүүлэх үүрэг, хариуцлага хүлээн ажиллаж, амьдарч байсан гэхэд нэг их хилсдэхгүй. Өөрийн гэсэн бодолтой, бүтээлч сэтгэлгээтэй хүмүүсийн нам, засгийн болоод байгууллагын удирдах ажилтны бодлого, санаанаас зөрсөн үзэл бодол, санааг сонсож, хүлээж авахдаа төр засгийн бодлогыг эсэргүүцэж байгаа мэтээр ойлгож хардах, сэрдэх талаас голчлон хандаж, зэмлэж, шийтгэдэг байснаас тэр үед өөрийн хүсэл, зоригор амьдарч, ажиллах боломж тун хязгаарлагдмал байсныг баталж нотлох хүн өнөөдөр ч цөөнгүй бий.

Харин өнөөдрийн бидний шилжин орж байгаа нийгэм маань хүн бүр жинхэнэ өөрийнхөө болоод үр хүүхдийнхээ ирээдүйн төлөө ажиллаж, амьдрах учиртай нийгэм болоод байгаа нь өдрөөс өдөрт мэдрэгдэж байна. Гэтэл өнөөгийн манай залуучууд (оюутан, сурагчид)-ыг харахад өөрсдийн ирээдүй, маргаашийн талаар тун багахан бодож, амар хялбар замаар идэх хоол олдвол идээд, зугаалж цэнгэхийг илүүтэйд үзсэн, ойрын бодолтой, омголон зантай, олон ааштай хүмүүс болж төлөвших хандлагатай байгаа нь нүдэнд ил харагдаж, чихэнд илүү сонсогдсоор байх юм. Хүн чухамдаа өөрийнхөө өдөр тутмын үйл хөдлөлөөр өөртөө тодорхой шинж чанар, зан төлөв, итгэл, үнэмшлийг бий болгон төлөвшүүлж, амьдралын утга учраа төсөөлдөг болж, тэр нь түүний өдөр тутмын үйл ажиллагаа, зан төрхийн чиг хандлагыг тодорхойлдог нь зүй ёсны асуудал.

Манай орны хувьд “боловсролтой” гэгдэх иргэд, “боловсрол олгодог” гэх сургуулийнхаа тоогоор дэлхийн аль ч улсаас дутахгүй билээ. Гэтэл иргэдийн маань биеэ авч яваа байдал, ажиллаж, амьдрахын арга ухааны төлөвшил нь өөрөө өөрийнхөө хувь заяаны эзэн болох болон нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангах талаас нь харахад ихээхэн учир дутагдалтай байгааг бид өдөр бүр, алхам тутамдаа харж байна. Тэднээс “Хүүхээ чи өөрийнхөө ирээдүйн талаар ямар төсөөлөлтэй байна вэ?” гэж асуухад тэдний олонх нь тодорхой бодсон зүйлгүй, хийл “толгойгоо маажих”-аас хэтрэхгүй байна. Ер нь “боловсрол” гэдгийг ч “сургуульд орж сурсан болж төгсөж гарахын нэр”-ийн төдийд ойлгодог байдал багагүй ажиглагддаг. Эцэг, эхчүүд нь ч “хүүхдээ хүнд үзүүлэх юмтай болгох” гэж сургаж байгаа байдлаар ярих нь ч бий. Бараг бүх шатны сургууль, багш нар маань ч “боловсрол олгохын тулд сургах ёстой” гэж ойлгоод, бас “сургасан болж төгсгөдөг” байдал байсаар байгааг үгүйсгэх аргагүй.

Үүний гол учир шалтгааныг миний хувьд боловсролын (үйлчилгээний) зорилгыг буруу тодорхойлон томъёолж байгаатай холбоотой гэж үздэг. Өнөөдрийн боловсролын салбарт мөрдөж байгаа хууль эрх зүйн бараг бүх баримт бичиг болон сайд, дарга, багш, сурган хүмүүжүүлэгчид, судлаачдын хэлж ярьж, бичиж боловсруулж байгаа зүйлд “сургах”, “боловсрол олгох”, “мэргэжил эзэмшүүлэх”, “мэргэжилтэн бэлтгэх” гэсэн үг, өгүүлбэрүүд түгээмэл байгааг төвөггүй олж харж болно. Эндээс боловсрох, сурах, мэргэжил эзэмших, мэргэжилтэн болоход суралцагчийн өөрийнх нь хүчин чармайлт, оролцоо бараг хэрэггүй мэт харагдана.

Тэгэхээр суралцагчид нь “Биднийг “сургаад”, “боловсруулаад”, бидэнд “мэргэжил эзэмшүүлээд”, “мэргэжилтэн болгоод” өгөх юм байна” гэсэн санааг л авахаас бус би өөрөө “сурах ёстой”, “боловсрох ёстой”, “мэргэжил эзэмших ёстой”, “мэргэжилтэн болох ёстой” юм байна гэсэн өөр рүүгээ хандсан бодол, зорилт, шаардлагыг олж харахгүй, ухаарахгүй байх нь аргагүй ч юм шиг. Үнэндээ ч манай бага, дунд, дээд боловсролын аль ч шатны сургуульд, суралцагчдын сурч, боловсрох ажилдаа хандаж байгаа байдлыг харахад тэд маань яг ил хэлэхгүй байгаа ч үнэн байдал дээрээ “сургууль, багш нар л биднийг сургах ёстой” гэсэн шиг хандаж байгаа нь илэрхий харагддаг. Багш нар ч өөрсдөө ийн ярилцах нь бий. Гэтэл бодит байдал ийм байхад чухам “яагаад ингээд байна вэ?”, “яаж энэ байдлыг засах вэ?” гэж бодож, ийм байдлыг засах

талаар боловсролын байгууллага, багш сурган хүмүүжүүлэгчид маань тодорхой зүйл хийхгүй байна вэ? Яагаад ийм чанаргүй үйлчилгээ (сургалт) байсаар байтал, болоод, бүтээд байгаа юм шиг байсаар байна вэ?

Эндээс багш нарынх нь багшилж байгаагийнхаа, улмаар багшлах ажил хийж амьдарч байгаагийнхаа утга учрыг хэр ойлгож, яаж хандаж байгаа нь ч харагдаад байх шиг. Хүүхдүүд маань ч сургуульд сурч байх үеэсээ ийм байдлыг өдөр тутам ажиглаж харсаар байгаад “Амьдрал гэдэг ер нь нэг иймэрхүү л өдөр хоног өнгөрөөж, амиа аргацаан цалин хөлс авч, бие биенээ хуурахын нэр юм байна” гэсэн итгэл үнэмшилтэй болчихож байгаа юм биш биз? Чухам л ийм байдлаар “бэлтгэгдсэн” төр засгийн албан хаагчид болон бүх шатны ажилтан, ажилчид маань ажил албандаа яаж хандаж байгааг ч бид бас өдөр бүр харсаар байна биш үү.

Ийм байдлаас гарахын тулд манай орны бараг бүх иргэд толгой дараалан дамжиж “боловсорч” гардаг ЕБС-иас эхлээд бүх шатны сургалтын байгууллагууд өөрийн сургуульд элсэн орж суралцан гарч байгаа суралцагч бүрт өөрсдийнхөө суралцаж байгаагийн болоод улмаар амьдралынхаа зорилго, утга учир чухам юу болохыг бодож цэгнэдэг, хийж байгаа үйл хөдлөл, ажил, амьдралдаа хариуцлагатай ханддаг ухаан суулгахыг үндсэн зорилгоо болгох хэрэгтэй байна. Үүнд багш нарынх нь өөрсдийн ажилдаа хандаж байгаа байдал, хүүхдүүдэд тавьж байгаа шаардлага, тэдэнтэй харьцаж, ажиллаж байгаа арга барил шийдвэрлэх үүрэг, нөлөөтэй болохоос бус энэ тухай хий сургамжлан яриад нэмэр багатайг бидний туулсан зам харуулж байгаа билээ.

Чухамдаа ам, ажил хоёр маань хэр нийлж байгаагаа манай багш нар хэр хянаж, үнэлж цэгнэдэг бол? Ямар ч л гэсэн, юун түрүү, суралцагчдад даалгавар өгч, шалгадаг арга барилаа өөрчлөх нь чухал болоод байна. Тухайлбал, наанадаж оюутан, сурагчдаар хийлгэх гэж байгаа ажил бүхнийхээ, тэдний өөрсдийнх нь цаашдын ажил амьдралд ямар ач холбогдолтойг ойлгуулах, тэдэнд юуг, яаж хийж сурах ёстойг нь ухааруулахыг хичээдэг болбол тэдний сурах хөдөлмөртөө хандах хандлага, ажил, амьдралынхаа утга учрын талаар тунгаан боддог болоход нь сайнаар нөлөөлөх учиртай.

4.Зөвхөн “зөв”-ийг хайхуй

Социализмын үед аливаа асуудалд нэг намын үзэл сурталд тохируулахын үүднээс ханддаг байсантай уялдан бараг бүх хүн ямар нэг зүйлд

“аль нь зөв юм бол?” гэж ханддаг болсноор өөрийн гэсэн үзэл бодол, итгэл үнэмшилгүй, зөвхөн нэг “зөв” гэсэн зүйлд хөтлөгдсөн шийд гаргаж, бусдыгаа ч тэр л үүднээсээ үнэлж, дүгнэж сурчихсан байлаа. Тэгээд ч төвлөрсөн тогтолцоотой холбогдон бие даан шийдвэр гаргах эрх, хэрэгцээ тэр бүр хэн бүхэнд байсангүй.

Харин олон ургальч үзэл, чөлөөт сэтгэлгээ, төвлөрсөн бус тогтолцоог хүлээн зөвшөөрсөн өнөө үед хүмүүст өөрсдийн ажил, амьдралын холбоотой асуудлуудаараа сонголт хийх, шийдвэр гаргахдаа өөрийн гэсэн байр сууринаас хандаж, бие даан өөрийн гэсэн үзэл бодолтойгоор ажиллаж сурах хэрэгцээ бий болжээ. Харин энэ үйл явцад нь манай иргэдийн алив зүйлд бусдын тогтоосон хэм хэмжээнд баригдан дагаж хандаж сурсан хэвшмэл сэтгэлгээ нь багагүй саад болж байгаа нь хүмүүсийн хоорондын харилцаанд ч харагдсаар байна. Тухайлбал, аль нэг намын үзэл баримтлал юмуу, эсвэл өөрийнхөө үзэл бодлыг туйлчлаад, түүнтэй нь тохироогүй юм бүрийг “буруу” гэж үзэн үл ойшоох, өөртэйгөө санаа зөрсөн хүн бүхнийг “тэнэг” гэж үзэн бусдын ямар ч үнэ цэнтэй үг яриаг үл сонсох байдал сургуульд сурч байгаа оюутан, сурагчдаас эхлээд бараг бүх хүн дээр харагддаг болж.

Үүний эх үндэс ч бас л суралцагчдын сургуульд суралцаж байх үеэс тавигддаг гэхэд болно. Тухайлбал, багш нар нь хүүхдүүдээс асуусан асуултдаа зөвхөн өөрсдийнхөө хүссэн болоод санаанд тохирсон хариулт авахыг хүсэж асуугаад, түүнийг нь хэлсэн хүүхдийг магтан сайшааж, өөр хариулт өгсөн хүүхдийг яагаад тэгэж бодож байгаагийг нь ч сонирхолгүй “биш байна, суу”, “буруу байна, муу”, “чи юу ч мэдэхгүй байна” гэж “үнэлж” харьцдагаас хүүхдүүд “Хүн ер нь хүний асуултад өөрт нь таалагдах хариулт л өгч байх ёстой юм байна” гэсэн ойлголттой болдог ч байж болох юм.

Үүнчлэн олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрдөггүй, өөрийн ажилтан, албан хаагчдад зөвхөн өөрийнхөө санасны дагуу хийж, гүйцэтгэж, хэлж ярихыг тулган шаарддаг дарга, сайд, удирдах ажилтнууд олон байгаа нь байгууллага, хамт олны хичээл, зүтгэл, идэвх санаачлага, хөгжилд саад болж, хувь хүмүүсийн хүсэл эрмэлзэл, бүтээлч идэвх санаачлагыг хаан боогдуулсаар байгааг анхаарахгүй байж хэрхэвч болохгүй.

Энэ бүхэн манай өнөөдрийн бүх салбарын өөрчлөлт, шинэчлэл удааширч байгаагийн хамгийн гол шалтгаан болж байгааг бид тэр бүр олж харахгүй байна. Ялангуяа социализмын үеэс бидний өдөр бүрийн ажил, амьдралд хэвшин, хэвийн мэт болж дассанд ээрх буруу хэвшлүүдээсээ

салахгүйгээр нийгмийн шинэ орчинд өөр өөрийн байр сууриа олж эрх чөлөөгөө эдлэн, аз жаргалтай ажиллаж, амьдрах ямар ч боломжгүйг ухааран ойлгох хэрэгтэй болоод байна. Үүнийг төр засаг, байгууллагын удирдах албан тушаалтнууд болон боловсролын салбарын багш, ажилтнууд хамгаас өмнө ухааран ойлгууштай.

Бүтээлч сэтгэлгээтэй, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрдөг удирдах ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгчид л өөрийн албан ажилтан, шавь нарынхаа хэрэгцээ, авьяас, сонирхлын дагуу ур чадвараа хөгжүүлэн урам зоригтой ажиллах нөхцлийг бүрдүүлж, өөрсдийнх нь хүсэл, сонирхолд тулгуурласан уян хатан арга барилаар хамт олныг удирдан зохион байгуулж, шинэчлэл, өөрчлөлтийг эрчимжүүлэн иргэн бүр өөрийн хувь заяаны эзэн болж сэтгэл хангалуун амьдрах хүмүүнлэг, ардчилсан нийгмийн төлөвшил, оршин тогтнохын үндсийг бүрдүүлж чадна.

ДҮГНЭЛТ

Ийм хүмүүс хэдийд, хаанаас төрөн гарч ирэхийг хүлээсээр байх уу?

Үгүй, ингэж хэрхэвч болохгүй. Өнөөдөр, үүнийг ухаарсан нэг хүн ч болов, яагаад ийм байгаагийн учир шалтгааныг зөвхөн өөрөөсөө (зөвхөн өөрөөсөө шүү, бусдаас биш шүү) хайж, өөртөө байгаа өчүүхэн ч болов алдаагаа олж арилгахын төлөө өөрийгөө шинэчлэн ажиллаж эхэлбэл байдал өнөөдрийнхөөс арай өөр болж эхэлнэ.

Ялангуяа, ирээдүйн иргэд, мэргэжилтэн болох өсвөр, залуу үеийнхэнтэй ажиллаж байгаа багш нар маань л бидэнд саад болж байгаа дээрх мэтийн буруу хэвшлүүдийн шалтгааныг олж харж, эдгээрийг халахын төлөө үлгэрлэн ажиллаж эхэлвэл “бидний хүсэн хүлээж байгаа шинэ сэтгэлгээ, арга барилтай сайд, дарга нар гарч ирж шинэ үзэл баримтлал тунхаглан өөрчлөлт хийж эхлүүлэхээс өмнө”, ирээдүйн иргэд маань алдаа, оноогоо олж харан ухаарч өөрсдийгөө мэдэрч, өөрчлөлтөд бэлтгэж эхлэх нь ойлгомжтой. Чухамхүү үүний учир л боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар гэж үздэг бус уу.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Боловсролын хүрээлэн. (2012). Боловсролыг жинхэнэ угаар нь шинэчлэе гэвэл ... (эргэцүүлэл). *Боловсрол судлал*. № 01, 57-64

Батхуяг, С. (2012, 10 сар 12). “Социалист сурган хүмүүжүүлэх ухаан”-д эргэлзэхүй. *Нээлттэй сургууль сонин*, 145